

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
166 ДУГААР ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 2 дугаар сарын 18-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.7, 46.8 дахь хэсэг, Монголын цахилгаан холбоо Хувьцаат компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дугаар заалтыг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн 2020 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1 (нэг) төгрөг байхаар тогтоон ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдрийг 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтсугай.
3. Ногдол ашгийг 2021 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгосугай.
4. Ногдол ашгийг холбогдох хууль, журмын дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-тай гэрээ байгуулан тарааж, тайланг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЛХАГВАСҮРЭН